

Үндэсний тэтгэврийн тогтолцоо нь даатгуулагчийн хамрагдсан даатгалын ангилалд ямарваа нэгэн өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох даатгалын газар мэдүүлсэн байхыг шаарддаг. Та манай цахим бүртгэлд Япон улсад ирснийхээ дараа, эсвэл ажиллаж байсан компаниас гарсан тухай мэдээллээ зөв өгөөгүйн улмаас Үндэсний тэтгэврийн даатгалд хамрагдсан талаарх мэдээлэл бүрэн бус байж болно. Хэрвээ та шилжилт хөдөлгөөн бүрийнхээ тухай мэдүүлээгүй тохиолдолд ирээдүйд хэрэгтэй үедээ өндөр настны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах боломжгүй болох магадлалтай. Иймээс, доорх маягтыг зааврын дагуу бөглөн холбогдох даатгалын газарт мэдүүлнэ үү.

Мөн та мэдүүлгээ өгч эхлээгүй байсан ч Японы Тэтгэврийн байгууллагын бүртгэлээс Үндэсний тэтгэврийн даатгалд хамрагдан шимтгэл төлөх тухай нэхэмжлэх явуулахыг анхаарна уу.

## Даатгалын хамрагдах ангилал, шилжилт хөдөлгөөний мэдүүлэг өгөх тухай

Дор дурдсан даатгуулагч (даатгуулагчийн гэр бүлийн хүн) нь ар талын хуудас дээр тэмдэглэсэн “мэдүүлэг өгөх шаардлагатай тохиолдол”-ын

-т хамрагдаж буй учир аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд мэдэгдэх шаардлагатай.

Даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэлээ бүрэн эсэхийг нягтлахын тулд доорх зааврын дагуу маягтаа бөглөөд холбогдох даатгалын газар мэдүүлнэ үү.

### ◆ Та даатгалын аль ангилалд хамрагдах вэ?

Энэхүү мэдүүлгийн хуудсын ар талд байгаа “Үндэсний тэтгэвэрт даатгуулагчийн ангилал”-ыг харна уу.

### ◆ Аль маягтыг хаана мэдүүлэх вэ?

(а) Даатгуулагч, эсвэл гэр бүлийн хүн нь даатгалын 1-р ангилалд мэдүүлэх шаардлагатай бол “Үндэсний тэтгэвэрт даатгуулагч” -ийн мэдүүлэх маягтад хавсаргах бичиг баримт” (KOKUMIN NENKIN NIHOKENSHA KANKEI TODOKESHO)-ыг бөглөөд харьяа засаг захиргааны нэгжийн даатгалын, эсвэл халамжийн ажилтанд мэдүүлнэ үү. Хавсаргасан маягт бөглөх загварыг харна уу.

Жич: Хэрвээ та “Хувийн дугаар” (Япон улс дахь хувийн дугаар)-аа мэдүүлэх тохиолдолд таны дугаарыг нотлох бичиг баримтыг хамт өгөх шаардлагатай. Энэхүү мэдүүлгийн хуудсын ар талд байгаа дэлгэрэнгүй зааврыг харна уу.

(б) Даатгуулагч, эсвэл гэр бүлийн хүн нь даатгалын 3-р ангилалд мэдүүлэх шаардлагатай бол “Үндэсний тэтгэврийн 3-р ангилалд даатгуулагчийн мэдүүлэх маягт” (KOKUMIN NENKIN DAISANGO(3 号) NIHOKENSHA KANKEI TODOKE)-ыг бөглөөд Үндэсний тэтгэврийн байгууллагын салбарт 2-р ангилалд хамрагдах гэр бүлийн хүнийхээ ажлын газраар дамжуулан мэдүүлнэ үү.

Мэдүүлгийн маягтын талаар ажлын газраасаа буюу Үндэсний тэтгэврийн байгууллагын салбараас лавлах боломжтой ба эсвэл дараах вэб сайтаас татан авч болно.

<https://www.nenkin.go.jp/>

Жич: Маягтыг бөглөхдөө ар талын хуудсан дээр байгаа зааврыг нягтлан уншина уу. Ямарваа нэгэн тодруулах зүйл байвал Үндэсний тэтгэврийн байгууллагын салбараас лавлана уу.

Энэхүү мэдүүлгийн хуудас нь таньд үлдэх хувь болох ба шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх үед хэрэг болно. Хэрэв та энэ захидлыг хүлээн авахаас өмнө маягт бөглөж, мэдүүлсэн бол энэхүү захидлыг хэрэгсэхгүй орхино уу.

## Даатгуулагч болон гэр бүлийн хүний мэдээлэл

Мэдүүлэг өгөх шаардлагатай хүний мэдээлэл

|                         |  |
|-------------------------|--|
| Суурь тэтгэврийн дугаар |  |
| Овог, нэр               |  |

2-р ангилалд даатгуулагчийн шимтгэл төлөлтийн бүртгэл

|                                                  |  |
|--------------------------------------------------|--|
| Тэтгэврийн даатгалын ангиллын нэр/дугаар         |  |
| Шимтгэл төлж дууссан огноо (ажлаас гарсан огноо) |  |
| Тэтгэврийн даатгалын ангиллын нэр/дугаар         |  |
| Шимтгэл төлж эхэлсэн огноо (ажилд орсон огноо)   |  |

Даатгуулагчийн гэр бүлийн хүний мэдээлэл

|                                          |  |
|------------------------------------------|--|
| Суурь тэтгэврийн дугаар                  |  |
| Овог, нэр                                |  |
| Төрсөн он, сар, өдөр                     |  |
| Тэтгэврийн даатгалын ангиллын нэр/дугаар |  |

Ямарваа нэгэн тодруулах зүйл байвал Үндэсний тэтгэврийн байгууллагын дараах салбарт хандана уу.

|  |
|--|
|  |
|--|

## Дараах тохиолдлуудад Үндэсний тэтгэврийн даатгуулагчийн мэдүүлгийн маягтыг өгнө. Үүнд:

- (1) 「第1号・第3号被保険者資格取得勸奨」 **1 болон 3-р ангиллын даатгуулагчийн бүртгэл**  
Компаний ажилтан, эсвэл төрийн албан хаагч (2-р ангиллын даатгуулагч) ажлаас гарсан тохиолдолд 1 болон 3-р ангиллын даатгуулагч болох тул уг шилжилт хөдөлгөөнийхөө тухай мэдэгдэх хэрэгтэй.
- (2) 「第1号被保険者該当勸奨」 **1-р ангиллын даатгуулагчийн бүртгэл**  
① 2-р ангиллын даатгуулагч (компаний ажилтан, эсвэл төрийн албан хаагч) ажлаас гарсан тохиолдолд тэжээлгэгч гэр бүлийн хүн нь 3-р ангиллаас 1-р ангилал руу шилжих мэдүүлэг өгнө.  
② 2-р ангиллын даатгуулагчийн (компаний ажилтан, эсвэл төрийн албан хаагч) тэжээлгэгч гэр бүлийн хүн нь орлоготой, тэжээлгэх шаардлагагүй болсон тохиолдолд 3-р ангиллаас 1-р ангилал руу шилжих мэдүүлэг өгнө.  
③ 2-р ангиллын даатгуулагч (компаний ажилтан, эсвэл төрийн албан хаагч) 65 нас давж өндөр настны тэтгэвэрт гарах тохиолдолд тэжээлгэгч гэр бүлийн хүн нь 3-р ангиллаас 1-р ангилал руу шилжих мэдүүлэг өгнө.  
④ Ажиллагсдын тэтгэвэрт даатгуулагч (65-аас дээш насны өндөр настны тэтгэвэр авч байгаа хүн үүнд хамаарахгүй) 70 нас хүрэхэд 2-р ангиллын даатгалд хамрагдах эрх дуусах тул тэжээлгэгч гэр бүлийн хүн нь 3-р ангиллаас 1-р ангилал руу шилжих мэдүүлэг өгнө.
- (3) 「未加入期間国民年金適用勸奨」 **Үндэсний тэтгэврийн шимтгэл нөхөн төлөх тухай**  
Даатгуулагчид ажил солигдсоны улмаас шимтгэл төлөгдөөгүй хугацаа байх тохиолдолд нөхөн төлөлтийн хугацаанд 1 эсвэл 3-р ангиллын даатгуулагч болох тул уг шилжилт хөдөлгөөнийхөө тухай мэдүүлнэ.
- (4) 「20歳国民年金適用勸奨」 **Үндэсний тэтгэврийн даатгалд 20 настай хамрагдах тухай**  
Даатгуулагч 20 настай ба 2-р ангилалд хамаарахгүй тохиолдолд 1 эсвэл 3-р ангиллын даатгуулагч болно.
- (5) 「34歳等国民年金適用勸奨」 **Даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тухай: 34 насны тусгай анхааруулга**  
Япон улсад хүрэлцэн ирээд, оршин суух хаяг бүртгүүлснийхээ дараа та Үндэсний тэтгэврийн даатгалд хамрагдах шаардлагатай байдаг. Хамрагдаагүй тохиолдолд даатгалын шимтгэл нөхөн төлөх шаардлагатай болох тул 34, 44, 54 нас хүрэхэд даатгалд хамрагдах тухай нэхэмжлэх илгээх болно.
- (6) 「第3号被保険者種別確認勸奨」 **Даатгуулагчийн 3-р ангиллын баталгаажуулалтын тухай**  
Ажил солигдох болон шилжилт хөдөлгөөний улмаас 2-р ангилалд даатгуулагчийн хамрагдах ангилал өөрчлөгдөх тохиолдолд 3-р ангилалын даатгалтай тэжээлгэгч гэр бүлийн хүн нь тухай бүрт шилжих мэдүүлэг өгөх шаардлагатай.
- (7) 「第3号被保険者該当勸奨」 **3-р ангилалд хамрагдах даатгуулагчийн тухай**  
2-р ангиллын даатгуулагчийн тэжээлгэгч гэр бүлийн хүн 3-р ангилалд хамрагдана.

Жич: Даатгуулагч нь Япон улсын гадаад улстай байгуулсан “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”-ийн дагуу даатгалд хамрагдан тэтгэврийн шимтгэл төлсөн бичиг баримттай тохиолдолд Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломжтой тул Тэтгэврийн байгууллагад хандана уу. “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”-ийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараах Япон улсын тэтгэврийн байгууллагын вэбсайтаас авна уу.

<https://www.nenkin.go.jp/service/kaigaikyoku/shaho-kyotei/kyotei-gaiyou/20141125.html>

### Үндэсний тэтгэврийн даатгуулагчийн ангилал

#### 1-р ангиллын даатгуулагч

ХАА, загас, ан агнуур, ой мсд бэлтгэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй болон оюутан зэрэг 20-оос дээш 60 хүртэлх насны хүн хамрагдана.  
[Энэ ангилалд хамрагдах даатгуулагч шимтгэлээ өөрөө төлнө.]

#### 2-р ангиллын даатгуулагч

Компани болон байгууллагад алба хашиж буй Ажиллагсдын даатгалд хамрагдсан, Нийгмийн хамгааллын эвлэлийн гишүүн (65 наснаас дээш өндөр настны болон ажиллагсдын суурь тэтгэвэр, Нийгмийн хамгааллын эвлэлийн гишүүний тэтгэвэр авдаг хүн 2-р ангилалд хамаарахгүй)  
[Энэ ангилалд хамрагдах даатгуулагч шимтгэлээ чалингаасаа суутгуулна.]

#### 3-р ангиллын даатгуулагч

2-р ангиллын даатгуулагчийн 20-оос дээш ба 60 хүрээгүй насны тэжээлгэгч гэр бүлийн хүн  
[Энэ ангилалд хамрагдах даатгуулагч шимтгэлээ өөрөө төлөхгүй.]

### “Тэтгэврийн нэмэлт шимтгэл” төлснөөр авах тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой

Сар бүрийн шимтгэл дээрээ 400 иен нэмж төлснөөр ирээдүйд авах өндөр настны суурь тэтгэврийн сар бүрийн хэмжээг өсгөж авах боломжтой. Нэмэлт шимтгэл төлсөн нийт сарыг 200 иенээр үржүүлж нэмэлт тэтгэврийн дүнг тооцно. Та 2 жилээс дээш хугацаанд нэмэлт тэтгэвэр авсан тохиолдолд нэмэлтээр төлсөн шимтгэлийн үнийн дүнгээ буцаан авах боломжтой.

\*Нэмэлт шимтгэл төлөх тохиолдолд хүсэлт гаргах хэрэгтэй. Нэмэлт шимтгэл төлөлт нь хүсэлт гаргасан сараас эхлэж бодогдоно. Дэлгэрэнгүй зүйлийг Тэтгэврийн байгууллагын салбараас лавлана уу.

### ["Хувийн дугаар" (Япон улс дахь хувийн дугаар) -аа ашиглан "Үндэсний тэтгэвэрт даатгуулагч"-ийн мэдүүлэх маягтад хавсаргах бичиг баримт (KOKUMIN NENKIN HINOKENSHA KANKEI TODOKESHO)]

Хэрэв та “Хувийн дугаар”-аа оролцуулан орон нутгийн захиргааны албанд өргөдөл гаргах бол өөрийн “Хувийн дугаар”-тай үнэмлэхээ авчрах хэрэгтэй. Хэрэв танд уг үнэмлэх байхгүй бол доорх (1) ба (2) дугаарт дурдсан бичиг баримтуудыг авчирна уу.

Хэрэв та өргөдлөө шуудангаар илгээх бол “Хувийн дугаар”-тай үнэмлэхнийхээ нүүр ба ард тал тус бүрийн хуулбарыг хавсаргана. Хэрэв танд уг үнэмлэх байхгүй бол доорх (1) ба (2) дугаарт дурдсан бичиг баримтуудын хуулбарыг илгээнэ үү.

(1) Таны “Хувийн дугаар”-ыг харуулсан оршин суух бүртгэлийн баталгаажуулсан хуулбар, эсвэл “Хувийн дугаар” олгосныг баталгаажуулсан албан бичиг (таны оршин суух бүртгэл дээрх нэр ба хаяг ижил тохиолдолд).

(2) Таны жолооны үнэмлэх, паспорт, оршин суугчийн үнэмлэх, эсвэл таныг “Хувийн дугаар”-ын жинхэнэ эзэмшигч болохыг баталгаажуулсан, дээрхтэй дүйцэхүйц бичиг баримт (Дэлгэрэнгүйг Тэтгэврийн байгууллагын салбараас лавлана уу.)